



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2021 оны 10 сарын 19 өдөр

Дугаар 441

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Зөвшөөрөл олгох тухай” 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Хил хамгаалах ерөнхий газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 200,410,201.39 (хоёр зуун сая дөрвөн зуун арван мянга хоёр зуун нэг төгрөг гучин есөн мөнгө) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан тээврийн хэрэгслийг Цагдаагийн ерөнхий газарт балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Хил хамгаалах ерөнхий газрын Ар тал, зэвсэглэл, инженер техник эрхэлсэн дэд дарга хурандаа Д.Ганбаатар, Цагдаагийн ерөнхий газрын Санхүү аж ахуйн албаны дарга, цагдаагийн хурандаа П.Батбаатар нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх, хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2021 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс /Д.Нарангэрэл/-т үүрэг болгосугай.

ДАРГА


Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132001344

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2021 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн
12 дугаар тогтоолын хавсралт



ХИЛ ХАМГААЛАХ ЕРӨНХИЙ ГАЗРЫН
БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

№	Автомашины марк улсын дугаар	Ашиглал- тад орсон огноо	Арлын дугаар	Балансын нийт үнэ (төгрөг)	Шилжүүлэн авах байгууллага
1	Дунд оврын автобус /Yutong ZK6710D5T/	2021	LZYTETC28 M1013760	200,410,201.39	Цагдаагийн ерөнхий газар
НИЙТ ДҮН				200,410,201.39	
				(хоёр зуун сая дөрвөн зуун арван мянга хоёр зуун нэг төгрөг гучин есөн мөнгө)	